



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/310

Улаанбаатар хот

「 Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 14,242,500.00 (арван дөрвөн сая хоёр зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Ө.Ган-Өлзий)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 13 нэр төрлийн 14,242,500.00 (арван дөрвөн сая хоёр зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Ө.Ган-Өлзий)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА

В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн Харилцааны Газрын
даргын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

Д/д	Хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ҮХХХК-ын шийдвэр
1	Суурин компьютер 2014	2	ш	6	600,000.00	3,600,000.00	2,850,000.00	750,000.00	Шатсан	актлах	татах
2	Камер	5	ш	2	160,000.00	320,000.00	224,000.04	95,999.96	Шатсан	актлах	татах
3	Сапон 2420	5	ш	1	700,000.00	700,000.00	350,000.10	349,999.90	Шатсан	актлах	татах
4	Принтер 1136 /залуучууд/	2	ш	1	132,000.00	132,000.00	104,500.00	27,500.00	Шатсан	актлах	татах
5	Принтер samsung	5	ш	1	860,000.00	860,000.00	429,999.96	430,000.04	Шатсан	актлах	татах
6	Өнгөт принтер /Койко/	2	ш	2	100,000.00	200,000.00	158,333.44	41,666.56	Шатсан	актлах	татах
7	Өнгөт принтер /Койко/	2	ш	1	100,000.00	100,000.00	0.00	100,000.00	Шатсан	актлах	татах
8	Зөөврийн компьютер	4	ш	2	3,500,000.00	7,000,000.00	7,000,000.00	0.00	Шатсан	актлах	татах
9	Суурин утас	2	ш	1	55,500.00	55,500.00		55,500.00	Шатсан	актлах	татах
Машин тоног төхөөрөмжийн дүн						12,967,500.00	11,116,833.54	1,850,666.46			
1	Хаалга	8	ш	2	400,000.00	800,000.00	350,000.04	449,999.96	Эвдэрсэн	актлах	татах
2	Тумбочкатай цагаан хөлтэй оффис ширээ /К	4	ш	1	200,000.00	200,000.00	175,000.06	24,999.94	Эвдэрсэн	актлах	татах
3	Бичгийн ширээ 4 хос /залуучууд/	5	ш	1	200,000.00	200,000.00	63,333.27	136,666.73	Эвдэрсэн	актлах	татах
4	Хурлын ширээ /НУБ/	5	ш	1	75,000.00	75,000.00	23,750.00	51,250.00	Эвдэрсэн	актлах	татах
Тавилга эд хогшил нийт дүн						1,275,000.00	612,083.37	662,916.63	0.00	0.00	
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						14,242,500.00	11,728,916.91	2,513,583.09	0.00	0.00	
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө					0.00		0.00	0.00			
Устгах хөрөнгө					0.00		0.00	0.00			
Татан төвлөрүүлэх хөрөнгө						14,242,500.00	11,728,916.91	2,513,583.09			

Худалдсанаас олох орлого	0.00	0.00	0.00	0.00		
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/	0.00	0.00	0.00	0.00		